

Төрийн албаны зөвлөлийн
2020 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн
360 дугаар тогтоолын 10 дугаар хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☒ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

☐ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Аймаг дахь Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар

Албан тушаалын нэр:

Инженерийн дэд бүтцийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Ажлын цаг

Ажлын өдрийн 8 цаг

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Нэгжийн нэр:

Барилга, хот байгуулалтын хэлтэс

Албан тушаалын ангилал, зэрэглэл

Дэс түшмэл, ТЗ-5

Ажлын байрны албан ёсны байршил:

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Барилгын салбарын хууль, холбогдох бусад хууль тогтоомж, Барилгын норм ба дүрэм, стандартын хэрэгжилтийг хангах чиг үүргийн хүрээнд үйл ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэлийн үр дүнг хэлтсийн даргын өмнө хүлээнэ.

Албан тушаалын зорилт:

- 1.Салбарын хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хэм хэмжээний актыг хэрэгжүүлэх, норм дүрэм, журам, зааврын хэрэгжилтийг хангах, шинэчлэх, боловсронгуй болгох;
- 2.Тусгай зөвшөөрлийн үндсэн дээр инженерийн барилга байгууламж, нийтийн аж ахуйн ажил, үйлчилгээ болон зөвлөх үйлчилгээ эрхэлж буй байгууллага, хуулийн этгээдийг мэргэжил, арга зүйгээр хангах, олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах;
- 3.Улс, орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих барилга, байгууламжийг шинээр барих, өргөтгөх, их засварын ажилд хийх захиалагчийн хяналт хийх, хот суурин газрын инженерийн дэд бүтцийг төлөвлөх, хэрэгжүүлэх;
- 4.Нэгжийн өдөр тутмын дотоод үйл ажиллагаанд оролцох, хэрэгжүүлэх, тайлагнах.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Гүйцэтгэх-Г, Хянах-Х, Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Барилгын салбарын талаар төрөөс баримтлах бодлого, Монгол улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулахад инженерийн дэд бүтцийн чиглэлээр санал өгөх, хэрэгжүүлэх;	Холбогдох хууль тогтоомжтой нийцсэн байна.	Г
	2.Барилгын салбарын хууль тогтоомж болон холбогдох хууль тогтоомж тэдгээрт нийцүүлэн гарах хэм хэмжээний акт, бусад баримт бичгийг боловсруулахад санал өгөх, хэрэгжүүлэх;	Судалгаа, дүгнэлт бодитой хийгдсэн байна.	Г
	3.Барилгын салбарын хууль, тогтоомжийн хэрэгжилтийг аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэх, сурталчлах, иргэн, хуулийн этгээдийг зөвлөгөө, мэдээллээр хангах;	Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.	Г
	4.Аймгийн хүн амын орон сууцны хэрэгцээг хангах дэд төсөл, хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах, шинэ техник технологи нэвтрүүлэх, эрэлт нийлүүлэлт, орон сууцны борлуулалт, үнэ өртгийн судалгаа хийх, үнэлэлт дүгнэлт өгөх.	Тооцоо, судалгааг үнэн зөв үндэслэлтэй боловсруулсан байна.	
	5.Инженерийн дэд бүтэц /шинээр барих, засварлах, өргөтгөх, шинэчлэх/-ийг ашиглалтад оруулах ажлыг зохион байгуулахад оролцох, санал, дүгнэлт гаргах;	Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.	Г
	6.Орон нутагт хийгдэж буй болон ашиглалтад орсон барилга байгууламжийн тооцоо, судалгааг хийх, мэдээллийн санд оруулах; → /(-)	Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.	Г

7.Орон нутагт ашиглагдаж инженерийн дэд бүтцийн барилга байгууламжийг паспортжуулж чанар аюулгүй байдлын түвшингээс хамааруулан эрх бүхий байгууллагаар ашиглалтын гэрчилгээг олгуулах ажлыг зохион байгуулах;	Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.	Г
8.Аймгийн нутаг дэвсгэрт байрлах инженерийн байгууламж, шугам сүлжээний ашиглалтад хяналт тавих, судалгаа хийх, бүртгэл хөтлөх, дүгнэлт өгөх, "Барилга байгууламжийн ашиглалтын дүрэм"-ийг хэрэгжүүлэх;	Норм, стандартын шаардлага хангасан байх	Г, Х
9.Хүлээн авсан барилга байгууламжийг улсын бүртгэлд тусгуулах, инженерийн байгууламж, тоног төхөөрөмжийн ашиглалтын зааварчлагаа, аюулгүй ажиллагааны горимын талаар ашиглагч байгууллагыг заавар зөвлөмжөөр хангах	Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.	Г
10.Хот суурин газар /аймаг, сум, баг/-ын ус дулаан, цахилгаан хангамж, ариутгах татуургын барилга байгууламж, эх үүсвэр, шугам сүлжээний хөгжүүрийн зураглал, мэдээллийн сангийн байнгын хөтлөлтийг хийх, баяжуулах, тэдгээрийн ашиглалтын байдлын судалгааг тогтмол эрхлэх;	Бүртгэл, судалгаа сайжирсан байна.	Г
11.Барилга угсралтын ажил, өргөтгөл шинэчлэлт, их засварын ажлын норм, нормативын баримт бичгийг мөрдүүлэх, судалгаа шинжилгээ хийх дүгнэлт гаргах, мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг зохион байгуулах;	Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.	Г
12.Инженерийн барилга байгууламж үе шатны ажлын явцад захиалагчийн хяналтыг гүйцэтгэж ил далд ажлын актыг баталгаажуулах, барилга байгууламжид гэмтлийн акт тогтоох, техникийн тодорхойлолт боловсруулах, хийгдсэн ажлын чанар, гүйцэтгэлд дүгнэлт өгөх, эрх бүхий байгууллага болон зураг төсөл зохиогчтой хамтарсан үзлэг шалгалт хийх, илэрсэн дутагдал зөрчлийг арилгуулах, техникийн шийдэл гаргах;	Зөрчил дутагдал буурсан байна.	Г
13.Төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран орон нутгийн хэмжээнд инженерийн дэд бүтцийн чиглэлээр хяналт, шинжилгээ үнэлгээний баг, ажлын хэсэгт ажиллах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх;	Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.	Г
14."Барилгын салбарын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн журам" болон "Барилгын салбарын мэргэжилтэн болон хуулийн этгээдийн бүртгэл хөтлөх, шинэчлэх, мэдээллийн санд байршуулах, мэдээллээр хангах ажлыг зохион	Мэдээллийн сангийн үйл ажиллагаа иргэдэд нээлттэй болсон байна.	Г

	байгуулах журам"-ыг хэрэгжүүлэн ажиллах.		
2 дугаар зорилтын хүрээнд	1.Барилгын салбарын инженер, техникийн ажилтнуудыг мэргэшүүлэх болон гүйцэтгэх чадварыг нэмэгдүүлэх, сургалтад хамруулах ажлыг зохион байгуулах, мэргэжил арга зүйгээр хангах;	Салбарын мэргэжилтнүүдийн мэргэжлийн чадаах дээшилсэн байна.	Г
	2.Хүлээн авсан барилга байгууламжийг улсын бүртгэлд тусгуулах, инженерийн байгууламж, тоног төхөөрөмжийн ашиглалтын зааварчлагаа, аюулгүй ажиллагааны горимын талаар сургалт явуулж ашиглагч байгууллагад мэргэжил, арга зүйн зөвлөгөө, мэдээллээр хангах;	Холбогдох хууль тогтоомжтой нийцсэн байна.	Г
	3.Орон нутагт барилгын салбарын мэдээллийн нэгдсэн санг бий болгож, баталгаат мэдээллээр иргэн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлэх;	Олон нийтэд зөв, бодитой мэдээллийг хүргэсэн байна.	Г
	4.Орон нутгийн хэмжээнд хийгдсэн судалгаа, хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, хууль, тогтоомжийн хэрэгжилт, зохион байгуулсан арга хэмжээ, хүрсэн үр дүн, мэдээллийн сангийн талаар олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах;	Олон нийтэд зөв, бодитой мэдээллийг хүргэсэн байна.	Г
3 дугаар зорилтын хүрээнд	1.Тусгай зөвшөөрлийн үндсэн дээр инженерийн барилга байгууламж, нийтийн аж ахуйн ажил, үйлчилгээ болон зөвлөх үйлчилгээ эрхэлж буй байгууллага, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавьж, авах арга хэмжээг тодорхойлох, санал оруулах;	Зохицуулалт нь хууль болон ёс зүйн хэм хэмжээнд нийцсэн байна.	Г
	2.Тусгай зөвшөөрлийн үндсэн дээр инженерийн барилга байгууламж, нийтийн аж ахуйн ажил, үйлчилгээ болон зөвлөх үйлчилгээ эрхэлж буй байгууллага, хуулийн этгээдийг мэргэжил, арга зүйгээр хангах, орон нутгийн хэмжээнд мэдээллийн сан үүсгэж, бүртгэлжүүлэх;	Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.	Г
	3.Гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч болон зөвлөх үйлчилгээ үзүүлэгчтэй байгуулсан ажил гүйцэтгэх гэрээг тогтоосон хугацаанд дүгнэж, хариуцлага тооцож ажиллах;	Гэрээний хэрэгжилт хангагдсан байна.	Г
	4.Дээд байгууллагын тушаал шийдвэр болон мэргэжлийн хяналт, эрх бүхий байгууллагаас хийсэн үзлэг, шалгалтын дүн, техникийн дүгнэлт, зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, зөрчил дутагдлыг арилгуулах, хэрэгжүүлэх.	Салбарын хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.	Г
4 дүгээр зорилтын хүрээнд	1.Нэгжийн өдөр тутмын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;	Байгууллагын үйл ажиллагаа тасралтгүй хэвийн явагдсан байна.	Г
	2.Стратеги болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хариуцсан чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ, шаардагдах зардлын тооцоо, төсөвт тусгуулах санал	Гүйцэтгэлийн төлөвлөгөө, түүний хэрэгжилт хангагдсан байна.	Г

	Боловсруулах, танилцуулах, хэрэгжүүлэх;		
	3.Барилгын салбарын бүртгэл, мэдээний маягтын дагуу инженерийн дэд бүтцийн барилга байгууламжийн мэдээлэл, тайланг гаргаж, холбогдох байгууллагуудад хүргүүлэх;	Гүйцэтгэлийн төлөвлөгөө, түүний хэрэгжилт хангагдсан байна.	Г
	4.Хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ, үйл ажиллагааны төлөвлөгөө түүний хэрэгжилтийг сар, улирал, жилээр гарган танилцуулах ажлыг хэрэгжүүлэх;	Үүрэг даалгавар цаг хугацаандаа бүрэн хэрэгжсэн байна.	Г
	5.Байгууллагын хурал, удирдах ажилтны шуурхай зөвлөгөөн, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлж, цаг үеийн шаардлагаар гарсан ажлуудыг тухай бүр зохицуулан зохион байгуулах, биелэлтийг тайлагнах;	Үүрэг даалгаврын биелэлт хангагдсан байна.	Г
	6.Байгууллагын дотоод дүрэм, журам, Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг мөрдлөг болгон ажиллах, төрийн захиргааны манлайллыг хэрэгжүүлэх;	Дүрэм, журам ёс зүйн хэм хэмжээнд заасан манлайлал бий болсон байна.	Г
	7.Хариуцсан үйл ажиллагааны хүрээнд бүрдүүлсэн баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэн, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивад хүлээлтэн өгөх.	Архивын ажлын үндсэн зааварт нийцсэн байна.	Г
	8.Байгууллагын болон нэгжийн өдөр тутмын үйл ажиллагаа, хурал, сургалт, олон нийтийн арга хэмжээнд оролцох.	Үүрэг даалгавар цаг хугацаандаа бүрэн хэрэгжсэн байна.	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.		
Мэргэжил	-Архитектур, хот төлөвлөлт /073102, 073103/; -иргэний ба үйлдвэрийн барилга, байгууламж /0732/; -цахилгаан, эрчим хүч /071302, 071303,071304, 071305/; -халдварт, агаар сэлгэлтийн инженер; -ус хангамж, ариутгах татуургын инженер.		
Мэргэшил	Төрийн албаны богино болон дунд хугацааны сургалтад хамрагдсан байна.		
Туршлага	Туслах түшмэл болон түүнээс дээш ангиллын албан тушаалд эсхүл мэргэжилээрээ 1-ээс доошгүй жил ажилласан байх.		
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	-Судалгааны арга зүй эзэмшсэн байх; -мэдээлэлд тулгуурлан бүтэц чиг үүргийн шинжилгээ хийх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх; -байгууллагын үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг илрүүлэх; -судалгааны үр дүнг харьцуулан үнэлэх, тайлбарлах; -нэрийн төвөгтэй мэдээллийг шинжилж, шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг тодруулах; -мэдээллийн үнэн, бодит байдлыг шалган нягтлах; -бусад.	
	Асуудал шийдвэрлэх	-Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг мандлан баримталж, үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчлэх; -өөрийн чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах; -асуудал шийдвэрлэх эдийн засаг, хууль зүйн	

		- үндэслэлийг тодорхойлох; - шаардлагатай асуудлаар судалгаа хийж, дүнг хариуцах; - хууль эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө өгөх мэдлэг, чадвартай байх; - асуудлын шийдалд шинэлэг байдлыг нэвтрүүлдэг байх; - бусад.
	Багаар ажиллах	- Өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах; - бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох; - ёс зүйн хэм хэмжээг сахж, зарчимч, тууштай, ажил хэрэгч байх, бусдыг дэмжих; - шинэлэг санаа, үйлчилгээг нэвтрүүлэх, шинэ санаачилга, бүтээлч үйл хандлагыг нэвтрүүлэх; - хувийн зохион байгуулалт, ажлын цаг ашиглалт сайтай байх; - бусад.
	Бусад	- Англи хэл эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах; - компьютерийн хэрэглээний програм, мэдээллийн дэвшилтэд техник, технологи ашиглах; - төрийн албан хэрэг хөтлөлт, бичиг хэрэг, монгол хэл, найруулга зүйн чадвартай байх; - багаар ажиллах, багийн амжилтыг үнэлэх, дүгнэх, нэгжийн хамт олонд таниулах; - харилцааны оновчтой арга хэлбэрийг ашиглаж, асуудлыг шийдвэрлэх, мэдээллийг шуурхай хүргэх; - үндэсний бичгийн хэлээр уншиж бичих чадвартай байх; - төрийн болон хувь хүний нууцыг хууль тогтоомжийн хүрээнд хадгалах, хамгаалах.

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

- Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга
- Хэлтсийн дарга


Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

Бусад харилцах субъект:

- Төрийн болон нутгийн захиргааны байгууллагын хэлтэс, орон нутгийн харьяа газар, хэлтэс;
- Төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрүүдийн ажилтан;
- Иргэн, хуулийн этгээд, мэргэжлийн байгууллага.

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:
Албан тушаал:	Байгууллагын нэр:

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН ДАРГА  Ц.ТАНХҮҮ 2020 оны 11 дүгээр сарын 04-ны өдөр	ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ Шийдвэрийн огноо: 20 11 04 Дугаар: 360
VI. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫГ БАТАЛСАН:	
Байгууллагын нэр: Байгалийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар Шийдвэрийн огноо: 2021.01.12 Дугаар: А/02 ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА  2021 оны 01 дугаар сарын 12-ны өдөр	